



Д. МЯГМАРСҮРЭН

*Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн
сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
албаны тэнхимийн эрхлэгч, ахмад*

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ХАРУУЛ ХАМГААЛАЛТАД ХЯНАГЧИЙН ҮҮРЭГ ОРОЛЦОО, ТУЛГАМДАЖ БАЙГАА ЗАРИМ АСУУДАЛ

Монгол Улсын хэмжээнд хорих ялыг эдлүүлэх үйл ажиллагааг явуулж байгаа Хорих байгууллагууд нь нийгмийн өмнө хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд ялтныг олон нийтээс тусгаарлан баривчлах болон хорих ялыг албадан эдлүүлэх, ялтны аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, ялтнаас нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх зэрэг үйл ажиллагааг дэглэм харгалзахгүй жигд хэрэгжүүлдэг билээ Иймд дээрх үүргийг хэрэгжүүлэх явцад хорих ангийн харуул хамгаалалтад ялтны зүгээс хянагчийн үүрэг гүйцэтгэгч, улмаар албаны үйл ажиллагаанд сөрөгөөр нөлөөлөхийг оролдох, өөртөө ашигтай шийдвэр гаргуулахыг /ял завших/ эрмэлзэх, албан хаагчийг янз бүрийн аргаар эрхшээлдээ оруулахыг хичээх, албан хаагчийн эрүүл мэндэд халдах, бие биенийхээ амь насыг хохироох, эрүүл мэндэд халдах, харуул хамгаалалтад хүндрэл учруулах гэх мэт хорих ангийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зорилго бүхий үйлдлийг байнгын буюу тасралтгүй шинжтэйгээр үйлдсээр байна.

Түүнчлэн ялтан цаашид хорих анги, баривчлах байранд бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдэх, хорих ангийн харуул хамгаалалтыг сулруулах, албаны үйл ажиллагааны онцлогийг ашиглан хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийг эвдэх, зориулалтын саад, төхөөрөмжийг давж туулах замаар ганцаар болон бүлэглэн оргох, бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгдсээр байгаа нь харуул хамгаалалтын хэвийн үйл ажиллагаанд сөрөгөөр нөлөөлж байгаа гол хүчин зүйл юм.

Хорих байгууллагын харуул хамгаалалт гэдэг нь ялтныг олон нийтээс тусгаарлан тэднээс дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, үйлдсэн хэргийг илэрүүлэх, таслан зогсоох, холбогдох хууль, хорих ангийн

дотоод журам, цагийн хуваарийг чанд мөрдүүлэх, хорих анги болон ялтны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа идэвхтэй хэрэгжсэн байхыг хэлнэ.

Хууль эрх зүйн өнөөдрийн зохицуулалт нь хорих байгууллагыг ялтныг хуульд зааснаар хүмүүжлийн нөлөө үзүүлэх биш харин дахин давтан гэмт хэрэг үйлдэх хань хамсаатантай болгох, гэмт хэрэг үйлдэх талаар харилцан мэдээлэл, туршлага судлах, гэмт явдлаар мэргэших байдалд хүргэж, гэмт хэрэгтнүүдийг бэлтгэдэг уурхай, эсвэл хэд хэдэн төрлийн гэмт хэрэг үйлдээд аль хөнгөн гэмт хэрэгт ял шийтгүүлэн хорих байгууллагыг гэмт хэргээ нуун далдлах газар болгон ашиглаж байж болзошгүй гэж хууль хяналтын байгууллага, ард иргэдийн зүгээс үзэхэд хүргэж байна.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, жишиг дүрмүүдэд заагдсан шаардлагад нийцсэн ял эдлэх орчин нөхцөл тийм сайн бүрдээгүй байгаа учир нь гэмт этгээдүүдийн үйлдлийн арга, сэдэл нарийсч, улам зохион байгуулалттай болж, нийгэмд учруулж буй хор хохирол өсч буй үед анх болон давтан гэмт хэрэгтнүүдийг тус тусад нь ял эдлүүлэх, хар тамхи, мансууруулах бодис, хүн худалдаалах, мөнгө угаах, авилга хээл хахууль, албан тушаалын болон гомо, лесби, сэтгэцийн өөрчлөлтэй, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн хамсаатан, гадаадын иргэдийг ямар нөхцөлд ялыг хэрхэн эдлүүлэх орчин нөхцөл, хяналт хамгаалалтын стандарт батлагдаагүйгээс ялтнууд хорих ангийн дотоод журмыг зөрчих явдал буурахгүй байгаа нь Хорих байгууллагын хэмжээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 118 дугаар зүйлд ижил дэглэмтэй хорих ангид анх удаа ял эдэлж байгаа ялтныг давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнаас, засарч хүмүүжиж байгаа ялтныг засрал олохгүй байгаа ялтнаас, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн ялтныг тус тусад нь ял эдлүүлнэ гэсэн заалт өнөөдөр хэрэгжихгүй байгаад хүрч байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Хорих ангийн харуул хамгаалалтын үүргийг гүйцэтгэж байгаа алба хаагчдаас 60-70 хувийг зөвхөн ахлагч бүрэлдэхүүн голлож гүйцэтгэж байгаа билээ. Иймд нийгэмд гарч байгаа гэмт хэргийн тоо өссөнтэй холбогдуулан ялтны амьдрах байранд үүрэг гүйцэтгэж байгаа нэг хянагчид ноогдож байгаа ялтны тоо нь 80-100 байгаа нь доорх судалгаанаас харагдаж. Энэ нь үүрэг гүйцэтгэж байгаа хянагчид ажлын ачаалал их байгаагийн зэрэгцээ ялтанд тавих хяналт сулрах, мөн тэдний дундаас гэмт хэрэг гарах гарах эсрдэлтэй байдаг.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2008 оны 205/94 тоот тушаалаар Онгой болон чанга, жирийн дэглэмтэй хорих ангиудад 20 ялтан тутамд 1 харуул хамгаалалтын ажилтан /хянагч/ ногдохоор жишиг норматив баталсан байдаг. Энэ хамтарсан тушаал хэрэгжихгүй байгаа нь нэг жишээ юм.

Хорих байгууллагын харуул хамгаалалтад буюу хянагчийн үйл

ажиллагаанд сөрөгөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг дараах байдлаар авч үзвэл. Үүнд:

Хянагчийн ажлын ачаалал:

Дээрх хамтрасан тушаал хэрэгжихгүй байгаа нь Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа хянагч нь ажлын дэндүү их ачаалалтай үүрэг гүйцэтгэх судалгааны явцад харагдаж байна Жишээ нь Хорих 419 дүгээр анги /Хэнтий/ дансаар 320 гаруй жирийн дэглэмтэй ялтан ял эдэлж байхад Харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа нэг хянагч 70-80 ялтны дунд үүрэг гүйцэтгэж байна. Хорих 421 дүгээр хорих ангид /Амгалан/ дансаар 400 гаруй ялтан ял эдэлж байхад. харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа нэг хянагч 150-над ялтны дунд үүрэг гүйцэтгэж байна.

Хорих 413 дугаар ангид /Зүүнхараа/ дансаар 370 гаруй чанга дэглэмтэй ялтан ял эдэлж байхад харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа нэг хянагч 90 ялтны дунд албан үүргээ гүйцэтгэж байна. Хорих 425 дугаар ангид /Чойр/ дансаар 310 гаруй чанга дэглэмтэй ялтан ял эдэлж байхад харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа нэг хянагч 70 гаруй ялтны ялтны дунд албан үүрэг гүйцэтгэж байна. Хорих 433 дугаар анги /Дарьт/ дансаар 460 гаруй чанга дэглэмтэй ялтан ял эдэлж байхад харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа нэг хянагч 100 гаруй ялтны дунд албан үүргээ гүйцэтгэж байна.

Хорих 415 дугаар анги /Мааньт/ дансаар 450 гаруй чанга дэглэмтэй ялтан ял эдэлж байгаагаас харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа нэг хянагч 60 гаруй ялтны дунд албан үүргээ гүйцэтгэж байна. Хорих 443 дугаар анги /Хөвсгөл/ дансаар 80 гаруй жирийн дэглэмтэй ялтан ял эдэлж байгаагаас харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа нэг хянагч 20-25 ялтны дунд албан үүргээ гүйцэтгэж байна. Хорих 423 дугаар анги /Хархорин/ дансаар 360 гаруй жирийн дэглэмтэй ялтан ял эдэлж байхад харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа нэг хянагч 120 гаруй ялтны дунд харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байна. Хорих 439 дүгээр анги /Булган/ дансаар 300 гаруй онцгой дэглэмтэй ялтан ял эдэлж байхад харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа нэг хянагч 40 гаруй ялтны дунд харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байна.

2013 онд ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газраас Харуул хамгаалалтын ажилтнуудын үүрэг гүйцэтгэлт болон нэг хянагчид ноогдож байгаа ялтны судалгааг гаргахад нэг хянагч 70-80 ялтны дунд үүрэг гүйцэтгэж байна гэсэн судалгаа гарсныг Хууль зүйн яаманд танилцуулсан байдаг. Гэтэл энэ нөхцөл байдал өнөөдрийг хүртэл шийдэгдээгүй байна. Өнөөдөр хянагч ажлын ачаалалтай ажилласнаар ялтан бүрд тасралтгүй хяналт тавих үүргээ биелүүлж чадахгүйд хүрч улмаар ялтны дундаас гэмт хэрэг, зөрчил буурахгүй байгаа нь доорх судалгаанаас харагдаж байна

Жишээ нь: 2013 оны жилийн эцсийн байдлаар ялтны зүгээс гаргаж буй зөрчлийг өнгөөр авч үзвэл ажлын байраа орхин явсан 9, ажил хийхээс зайлсхийсэн 6, бусдыг дарамталсан эд зүйлийг булаасан 34, бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулсан 9, бусдын биед санаатай гэмтэл учруулсан 15, архи уусан 132, хориотой тоглоом тоголсон 23, алба хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн 111, гар утас хэрэглэсэн 1436, бусад зөрчил 304, хулгай хийсэн 3, нийт зөрчил 2082 гарсан байна. Энэ байдлыг Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажил хийхээс зайлсхийсэн зөрчил 2-оор буюу 25 хувиар, бусдын биед гэмтэл учруулсан 14-өөр буюу 48,2 хувиар, архи уусан 47-оор буюу 26.2 хувиар, хориотой тоглоом тоглосон зөрчил 8-аар буюу 25,8 хувиар буурсан бол ажлын байраа орхин явсан зөрчил 7-оор буюу 77,7 хувиар, бусдыг дарамталсан, эд зүйлийг булаасан зөрчил 4-өөр буюу, 11,7 хувиар өссөн, бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулсан зөрчил 5-аар буюу 55,5 хувиар, гар утас хэрэглэсэн 132-оор буюу 9,1 хувиар алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн зөрчил 19-өөр буюу 17,1 хувиар, бусад зөрчил 27-оор буюу 8,8 хувиар, нийт зөрчил 126 буюу 6.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Аливаа улсын нийгэм эдийн засгийн хөгжил, түүний түвшин зэрэг нь нийгмийн сэтгэл зүйтэй салшгүй холбоотой байдаг талаар олон жишээ дурдаж болох юм. Нийгэм-эдийн засгийн байдал хэдий чинээ баталгаагүй байна, зарим нэг ялтны сэтгэл зүй тогтворгүй, эмзэг байхын зэрэгцээ аливаа сөрөг үр дагавар дагуулж байдаг.

Хорих ял эдлэж буй ялтны сэтгэл зүйн Нийгэм-эдийн засгийн амьдралын аливаа өөрчлөлт, хөдөлгөөнийг маш эмзэг, сөргөөр хүлээж авдаг нь судалгааны ажиглалтаас харагдаж байна. Ингэснээр хорих ял эдлэж буй этгээдүүдийн сэтгэл санаа тогтворгүй байдалд орж бухимдсан үедээ хорих байгууллагын харуул хамгаалалтын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх, бусад ялтнуудтай муудалцаж, зодоо хийх эсвэл оргох гэмт хэргийг үйлдэх нөхцөл бүрдэж байдаг юм.

2. Зарим алба хаагчдын зүгээс хянагчийн ажилд сөрөгөөр нөлөөлөх хүчин зүйлс

а/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүй, үйлчилгээний стандартыг хөндөхгүй байхын аргагүй, уг стандартад зааснаар хорих байгууллагын ажилтан нь үйлчлүүлэгчтэй харьцахдаа гадаад төрөхөөрөө цэвэрч, соёлтой ажил хэрэгч, бусдад таатай сэтгэгдэл төрүүлэхээр байж, ажлын байранд цэргийн дүрэмт хувцасыг холбогдох дүрэмд зааснаар хэрэглэсэн байх ёстой. Мөн үйлчлүүлэгчийн зүгээс ирэх тааламжгүй харьцаанд ямарч тохиолдолд эелдэг тайван байдалтай, сэтгэл хөдлөлийн огцом өөрчлөлтийг илэрхийлэхгүй байж оновчтой зөв үг хэллэг хэрэглэн харьцах явдал юм.

Гэтэл хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтан төрөл бүрийн гэмт хэрэгт шийтгэгдсэн боловсролтой, боловсролгүй, мэргэжилтэй, мэргэжилгүй, ууртай, намуун дөлгөөн, аймхай, зоригтой, зусарч, бялдууч, шударга гээд өөр өөр үзэл бодол, зан араншинтай этгээдүүтэй өдөр тутам харилцдаг онцлогтой. Ингэж харьцахдаа ажилтан нь энгийн иргэдийн адил чөлөөтэй үг хэрэглэж харьцах биш зохих хууль, тогтоомжийн хүрээнд харьцдаг байх шаардлага тавигддаг. Өөрөөр хэлбэл харуул хамгаалалтын ажилтан нь албаны өөрт байгаа мэдээлэл, хувийн мэдээлэл, хувийн хандлага байр суурь, санаа бодлоо нэг их ойлгомжтой тодорхой, бүрэн илэрхийлэхийг хууль журмаар хязгаарласан байдаг онцлог бий.

б/ Хорих ангийн дотоод журмыг алба хаагчдын зүгээс ялтантай хүнлэг, энэрэнгүй, хүний хууль ёсны эрх, эрх чөлөөг хүндэтгэж эрүүдэн шүүхээс ангид байх, ял шийтгэл, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр ялгаварлан харьцахыг хориглоно гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл ялтантай харьцахдаа “та” эсхүл өөрөөсөө ахмад настай ялтныг “гуай” гэх зэргээр хүндэтгэлтэй, албаны байдлаар харьцах байтал өнөөдөр зарим нэг алба хаагч хууль дүрэм, журмыг сайн олгоогүйгээс ялтантай “Ахаа, эгчээ, найзаа, хөгшөөн гэж дуудах, ажил үүргийн хүрээнд харьцахаас өөрөөр албаны бус байдлаар тухайлбал хууч хөөрөх, тоглож наадах, хувийн шинжтэй зүйл ярих зэрэг нь ялтантай хувийн харьцаа тогтоох гол хүчин зүйл юм.

в/ Нийтийг хамарсан баяр ёслол, сургалт бусад арга хэмжээний үед ялтнуудыг хочоор нь буюу доромжилсон байдлаар дуудах, элзэв доромжилсон буюу хараалын үг хэллэг хэрэглэснээр тухайн алба хаагчийн талаарх ялтнуудын дундах үнэлэмж буурч ингэснээрээ тэр алба хаагч эргээд ямарч сөрөг асуудалд орж болох нөхцөл бүрдэх гол хүчин зүйл юм. Жишээбэл: 1995 онд Мааньт дахь чанга дэглэмтэй хорих ангиас ялтан Ч.Дүгэрээ, Сугар нарын 9 ялтан харуулд хүч хэрэглэн, галт зэвсэг, машин техникавч оргосон. 1996 онд Авдрант дахь гяндангаас ялтан Ч.Чулуунбаатар, Н.Лхагвасүрэн, Б.Төртогтох нар 5 хүний амь насыг зэрлэгээр хөнөөж оргосон эмгэнэлт тохиолдол, мөн 2005 онд Хорих 421-р ангид ял эдэлж байсан Ч нь зөвхөн нэг ээлжийн бие бүрэлдэхүүнийг сонгон ээлжин дээр нь дотно яриа өрнүүлэн цай, кофе өгөх зэргээр албаны хүмүүсийг өөртөө 6 сар орчим дасгаж байгаад боломжтой нэг өдрийг сонгон ээлжийн бие бүрэлдэхүүнд орой амрах тооны дараа кофе найруулж өгөхдөө нойрны эм хийж унтуулаад оргон зайлсан, 2009 онд Дамжин өнгөрүүлэх хорих ангиас ялтан Н харуул хамгаалалтын ажилтанг хутгалан оргон зайлсан гэх мэт олон жишээг дурдаж болно.

Дүгнэлт

Дээрх харуул хамгаалалтад нөлөөлж байгаа сөрөг хүчин зүйлүүд нь нэмэгдэж нийгэмд хор аюул ихтэй гэдэг нь хэнд ч ойлгомжтой юм. Мөн хорих ангийн харуул хамгаалалтын хэвийн үйл ажиллагаа доголдож байдаг, өөрөөр хэлбэл ялтан оргох, дахин давтан гэмт хэрэг үйлдэх явдал өндөр магадлалтай (оргож явах үедээ нийгэм, иргэдэд эд хөрөнгийн болон эрүүл мэндийн хохирол учруулах магадлал өндөр) нийгмийг айдаст автуулдаг зэрэг сөрөг хандлагыг өөртөө агуулж байдаг.

Хянагчид ажлын ачаалал их байгаагаас шинээр томилогдсон хянагч ажлаасаа шантрах, цаашлаад ажлаасаа гарах үндэслэл бий болж байна гэж дүгнэхэд хүрч байна.

Хорих байгууллагын хянагчийн ажлын ачааллыг бууруулах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлснээр алба хаагчийн ажиллах таатай орчин бүрдэх, цаашлаад Хорих байгууллага болон алба хаагч, ялтны аюулгүй байдлыг хангаж ажиллах эерэг нөхцөл байдал үүсэх ач холбогдолтой.

Мөн Хорих ангийн харуул хамгаалалтад эерэг, сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн шалтгаан, нөхцлийг нарийвчлан судлаж, түүний үндсэн дээр шинжлэх ухаан техникийн сүүлийн үеийн ололтыг өргөн ажиллах, гарсан үр дүнг амьдралд нэвтрүүлэх явдал чухал юм гэж дүгнэж байна.

Санал.

Хорих байгууллагын харуул хамгаалалтын хэвийн үйл ажиллагаа хангах, мөн Хянагчийн ажлын ачааллыг бууруулах үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

1. Хорих байгууллагад ажиллах харуул хамгаалалтын ажилтны тоог батлагдсан нормативийн дагуу нэмэгдүүлэх.

2. Өнөөдрийн байдлаар албан тушаалаар нь нэрлэн байгаа Хянагч гэсэн нэр томъёог мэргэжлийн нэр “Харуул хамгаалалтын албаны ажилтан” гэх нэршлээр нэрлэж үйл ажиллагаандаа ашиглах.

3. Хорих ангийн дотоод албадын ажлын уялдаа холбоог сайжруулж сэтгэлзүйч, нийгмийн ажилтны мэргэшлийн түвшинг дээшлүүлж сэтгэл засал, сэтгэц онош хийж ялтныг ангилан сургалт хүмүүжлийн ажлыг ялгавартай зохион байгуулах.

4. Харуул хамгаалалтын албан хаагчдыг давтан сургах, онол практикийн нэгдлийг хангах зорилгоор жилд 2-оос доошгүй сарыг мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд зориулдаг байх сургалтын эрх зүйн орчинг бий болгох.

Ном зүй

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. УБ. 2013 он
3. А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн сурах бичиг. УБ. 2012 он.
4. Б.Нямгомбо, Ч.Хүрэлбаатар. Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа. УБ. 2013 он.
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл. УБ. 2013 он. №02
6. Эрх зүй албаны мэдээлэл сэтгүүл. УБ. 2013 он. №03